

Product Data Sheet

Edition 22/08/2011

Identification no:

02 04 02 03 001 0 000039

Sikadur®-31 CF Normal

Sikadur®-31 CF Normal

2 Бүрэлдэхүүнт тиксотропик эпоксидын цавуу

Бүтээгдэхүүний тодорхойлолт

Sikadur®-31 CF Normal нь чийгэнд тэсвэртэй тиксотропик суурьцай 2-бүрэлдэхүүнт бүтээцийн цавуугаас гадна +10°C +30°C-д хэрэглэх зориулалттай тусгай дүүргэгч болон эпоксидын резины нэгдэл бүхий засварын зуурмаг юм.

Хэрэглээ:

Дараах бүтээцэд цавуу болон засварын зуурмагын зориулалтаар хэрэглэнэ:

- Бетон хийц эдлэл
- Байгалын гаралтай хатуу чулуу
- Шаазан болон мяндаслах цементэд
- Шавардлага, Чулуун ба тоосгон өрлөгт
- Ган, төмөр, хөнгөн цагаан эдлэл
- Модон эдлэл
- Хуванцар болон эпоскид эдлэл
- Шилэн эдлэл

Заслын зуурмаг болон цавуу зориулалтаар хэрэглэгдэх талбай:

- Өнцөг буланг засах
- Нүх сүв бөглөх зориулалтаар
- Босоо чиглэлтэй болон таазны засварт хэрэглэж болно

Залгаас болон гадаргуу дээрх хагарлын засварт:

- Залгаас болон хагарлын өнцөг булангын засварт хэрэглэнэ

Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

- Бүтээгдэхүүнийг холих болон хэрэглэхэд хялбар
- Хуурай болон чийгтэй бетоны гадаргууд хэрэглэж болно
- Олон төрлийн барилгын материалтай барьцалдан наалдах чадвар сайтай
- Цавуулаг чанар маш сайн
- Тиксотропик буюу босоо болон таазны засварт хэрэглэхэд ургахгүй
- Эхэн болон эцсийн үеийн механик буюу барьцалтын бат бэх маш өндөр
- Элэгдэлд тэсвэртэй
- Шингэн болон уурны нэвчиртэнд тэсвэртэй
- Химийн бодист тэсвэртэй
- Бэхжих явцдаа агшилт өгдөггүй

Construction

Sika®

- Холих явцыг хянахад зориулсан өөр өөр өнгийн бүрэлдэхүүнтэй
- Суурь түрхлэг шаардлагагүй

Тестүүд

Зөвшөөрөл / стандартууд EN 1504-4 ийн дагуу туршигдсан

Бүтээгдэхүүний мэдээлэл

Хэлбэр

Өнгө А хэсэг: Цагаан
 Б хэсэг: Хар саарал
 А + Б зуурмаг: Бетонон саарал

Сав баглаа боодол 2 кг (А+Б) лаазтай савлагаатай
 1 хайрцаганд 12 сет бүтээгдэхүүн орно

Хадгалалт +5°C+30°C орчинд сав баглааг онгойлгоогүй, бүрэн бүтэн байгаа тохиолдолд үйлдвэрлэсэн хугацаанаас хойш 24 сар хадлагах боломжтой. Хөлдөх аюулгүй, хуурай орчинд хадгалах шаардлагатай

Техникийн мэдээлэл

Химийн суурь Эпоксидын резин

Нягт (+20°C орчинд) 0,9 ± 0,1 кг/л (+23°C орчинд А+Б хэсгийг хольсон тохиолдолд)

Гулзайлт Босоо чиглэлтэй гадаргуу дээр 15 мм-ийн зузаантай түрхлэг гулзайлт гарахгүй (EN 1799-д нийцсэн)

Үе давхрын зузаан Давхарлаж түрхсэн тохиолдолд хамгийн ихдээ 300 мм.

Эзлэхүүний өөрчлөлт Агшилт: Ямар ч агшилтгүйгээр бэхжиж хатуурна

Дулааны тэлэлтийн Коэффициент W: (EN 1770-д нийцсэн)
 Коэффициент +23°C + 60°C-ийн орчны хэм тутамд $5,9 \times 10^{-5}$

Дулааны тогтвортой байдал (ISO 75-д нийцсэн)
 Дулаан хугарлын температур = +49 °C (7 өдөр/ +23°C орчинд)
 (зузаан 10 мм)

Механик / Физик хүчин зүйлүүд

Шахалтын бат бэх (DIN EN 196-д нийцсэн)

Бэхжих хугацаа	Бэхжих орчны температур		
	+ 10°C	+ 23°C	+ 30°C
1 хоног	25 - 35 кг/см ³	45 - 55 кг/см ³	50 - 60 кг/см ³
3 хоног	40 - 50 кг/см ³	55 - 65 кг/см ³	60 - 70 кг/см ³
7 хоног	50 - 60 кг/см ³	60 - 70 кг/см ³	60 - 70 кг/см ³

Гулзайлтын бат бэх

(DIN EN 196-д нийцсэн)

Бэхжих хугацаа	Бэхжих орчны температур		
	+ 10°C	+ 23°C	+ 30°C
1 хоног	11 - 17 кг/см ³	20 - 30 кг/см ³	20 - 30 кг/см ³
3 хоног	20 - 30 кг/см ³	25 - 35 кг/см ³	25 - 35 кг/см ³
7 хоног	25 - 35 кг/см ³	30 - 40 кг/см ³	30 - 40 кг/см ³

Суналтын бат бэх

(ISO 527-д нийцсэн)

Бэхжих хугацаа	Бэхжих орчны температур		
	+ 10°C	+ 23°C	+ 30°C
1 хоног	2 - 6 кг/см ³	6 - 10 кг/см ³	9 - 15 кг/см ³
3 хоног	9 - 15 кг/см ³	17 - 23 кг/см ³	17 - 23 кг/см ³
7 хоног	14 - 20 кг/см ³	18 - 24 кг/см ³	19 - 25 кг/см ³

Барьцалтын бат бэх

(EN ISO 4624, EN 1542 болон EN 12188-д нийцсэн)

Хугацаа	Орчны температур	Гадаргуу	Барьцалтын бат бэх
1 хоног	+ 10°C	Хуурай бетон	> 4 кг/см ³ *
1 хоног	+ 10°C	Чийгтэй бетон	> 4 кг/см ³ *
1 хоног	+ 10°C	Ган төмөр	6 - 10 кг/см ³
3 хоног	+ 10°C	Ган төмөр	10 - 14 кг/см ³
3 хоног	+ 23°C	Ган төмөр	11 - 15 кг/см ³
3 хоног	+ 30°C	Ган төмөр	13 - 17 кг/см ³

*100 хувь бетоны гэмтэл

Е-модуль

Суналт: (ISO 527-д нийцсэн)

~5'000 кг/см³ (23°C орчинд 14 хоногийн дараа)

Шахалт:

(ASTM D695-д нийцсэн)

~4'600 кг/см³ (23°C орчинд 14 хоногийн дараа)**Суналтын тасралт**

(ISO 75-д нийцсэн)

0,4 ± 0,1% (23°C орчинд 7 хоногийн дараа)

Системийн мэдээлэл**Хэрэглээний мэдээллүүд****Зарцуулалт**Sikadur®-31 CF Normal нь 1 мм-ийн зузаанд тутамд ~1,9кг/м² орно.**Гадаргуун чанар**

Бетон болон шавардлага нь хамгийн багадаа 28 хоног бэхэжсэн байх шаардлагатай.

Гадаргуун бат бэхийг шалга (бетон, чулуун болон өрлөг хавтангууд, байгалийн чулуу)

Гадаргуу нь хуурай, тос тосоол, бетон арчилгааны бодисууд, будаг түрхлэгүүд болон бусад бохирдол болон сул хэсгүүдээс бүрэн ангид байх хэрэгтэй.

Төмөр гадаргуу дээр үүссэн зэврэлтийг цэвэрлэсэн байх.

Гадаргуу бат бэх байж элдэв сул хөдөлгөөнтэй, бутрамтгай хэсгүүдийг хуулж авах шаардлагатай.

Гадаргууг бэлдэх

Бетон, шавардлага, чулуу, тоосго:

Гадаргуу бат бэх байж, элдэв бохирдол, тоосноос сайтар цэвэрлэж, дээр нь тогтсон ус үлдээж болохгүй. Сул, хөдөлгөөнтэй, бутрамтгай хэсгүүдийг хуулж авах шаардлагатай.

Ган төмөр гадаргуу:

Даралтад үлээгч болон тоос соруулагчаар гадаргууг сайтар цэвэрлэсэн байх шаардлагатай.

Хэрэглэх нөхцөл / Хязгаарлалт

Гадаргуун температур

хамгийн багадаа +10°C / хамгийн ихдээ +30°C

Орчны температур

хамгийн багадаа +10°C / хамгийн ихдээ +30°C

Материалын температур

Sikadur®-31 CF Normal бүтээгдэхүүнийг хэрэглэхээсээ өмнө +10°C +30°C орчинд хадгалах хэрэгтэй.

Гадаргуу дахь чийгшил

Бага зэргийн чийгтэй бетон дээр Sikadur®-31 CF Normal-ийг хэрэглэхдээ цавуугаа гадаргуун дээр сайтар нягтруулж дарж өгөх хэрэгтэй.

Шүүдрийн цэг

Конденсаци буюу өтгөрөхөөс сэргийл.
Хэрэглэх үеийн гадаргуун дулаан хамгийн багадаа +3°C-ээс дээш байх шаардлагатай.

Хэрэглэх заавар

Холих

А хэсэг : Б хэсэг = жингийн болон эзлэхүүний 2 : 1 харьцаатай байна

Холих хугацаа



А болон Б цавууг хамгийн багадаа 3 минутын турш зориулалтын эргүүлэгт хошуутай цахилгаан холигч ашиглан жигд удаанаар (хамгийн ихдээ 300 грт хүчээр) бүтээгдэхүүнийг нэгэн жигд саарал өнгөтэй болтол нь хольж өгнө. Холих үед цавуунд бөмбөлөг үүсэхээс сэргийлээрэй. Үүний дараа цавуугаа цэвэр хувинд хийгээд дахин жигд удаан хурдтайгаар 1 минутын турш хольж цавуун дахь бөмбөлөгийг багасгах хэрэгтэй. Засварын ажлын хэмжээ болон нээлттэй байх хугацаанд тохирох хэмжээний цавууг л хутгах хэрэгтэй.

Хэрэглээ

Sikadur®-31 CF Normal-ийг нимгэн үе түрхэх тохиолдолд хусуур, шүдтэй болон шүдгүй ниви (эсвэл бээлийтэй гараараа) ашиглан бэлдсэн гадаргуу дээр түрхэнэ.

Засварын зуурмаг хэлбэрээр хэрэглэх тохиолдолд хэв хашмал бэлдэх хэрэгтэй

Таазанд төмөр эдлэлийг хооронд наах тохиолдолд шавардлагааны зузаанаас хамааран (5 мм-ээс ихгүй) ерөөний температурт хамгийн багадаа 12 цаг доороос нь тулаас хийж өгөх хэрэгтэй. Бэлэн болсон зуурмагаа 15 минутын дараа бэлдсэн хэв хашмал руу агаар үүсгэхгүйгээр аядуухан хийж өгнө. Хэвтээ болон босоо түвшиний аль алинд ч Sika Grout зуурмагийг дээд түвшинг тултал дүүргэж өгөх хэрэгтэй.

Хатаж бэхжсэний дараа гадаргуу дээр алхаар тогшиж үзэх хэрэгтэй.

Цэвэрлэгээ

Ажил дууссаны дараа бүх багаж, тоног төхөөрөмжүүдээ хатахаас нь өмнө Sika® Colma Cleaner цэвэрлэгчээр цэвэрлэх хэрэгтэй. Хатаж бэхжсэн бодисыг зөвхөн механик аргаар л цэвэрлэх боломжтой.

Нээлттэй байх хугацаа

Нээлттэй байх хугацаа (200 гр) (EN ISO 9514-д нийцсэн)

+ 10°C	+ 23°C	+ 30°C
~ 145 минут	~ 55 минут	~ 35 минут

Нээлттэй байх хугацаа нь А, Б хэсгийг хольсоноос эхэлнэ. Бэхжих хугацаа нь халуун орчинд богино, сэрүүн орчинд удаан үргэлжилдэг. Цавууны хэмжээ их байх тусам бэхжилтын хугацаа богино байна. Халуун дулаан орчинд ажиллах чадварын уртасгахын тулд цавуугаа бага бага хэмжээгээр хэсэгчилж холих хэрэгтэй. Мөн ажиллах чадварыг уртасгахын тулд А:Б хэсгийг холихоос өмнө сэрүүн орчинд байлгах хэрэгтэй (+5°C хэмээс доош хадгалж болохгүй).

Хэрэглээний үеийн зөвлөмж / Хязгаарлалтууд

Sikadur® резинүүд нь тогтмол ачаалалтай нөхцөлд суулт өгөх боломж маш бага байхаар боловсруулагдсан бүтээгдэхүүн юм. Гэвч урт хугацааны турш тогтмол даацыг ачааллах бүтээцэд суултын хэмжээг урьдчилан тооцоолох шаардлага гарна. Тооцоолох ерөнхий арга бол бүтээцийн боломжит даацын хэмжээнээс урт хугацааны туршид тогтмол даацыг ачаалах суултын хэмжээ нь 20-25% бага байдаг. Иймээс бүтээцийн инженерүүдээс тухайн төслийн хувьд боломжит даацын хэмжээг тодорхойлуулах хэрэгтэй.

Дүгнэлт

Энэхүү Техникийн зааварчилгаанд лабораторийн туршилтын үндсэн дээр батлагдсан техникийн үзүүлэлтүүд тусгагдсан ба бодит үзүүлэлтүүд нь тухайн нөхцөл байдалд өөр өөр байж болно гэдгийг анхаарна уу.

Дотоодын хязгаарлалт

Тухайн улс орны дотоодын хууль тогтоомжоос хамааран уг бүтээгдэхүүний гүйцэтгэл ялгаатай хийгдэх боломжтой. Иймээс манай Техникийн хэлтэст холбогдож зөвлөгөө авах боломжтой.

Эрүүл мэнд, Аюулгүй Ажиллагааны мэдээлэл

Бүтээгдэхүүнийг зөв хэрэглэх, хадгалах, химийн бодисын хаягдлыг зайлуулах зэрэг Аюулгүй ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг мөн физик, экологи, хортой байдал болон бусад аюулгүй ажиллагаатай холбоотой мэдээллийг цогцоор агуулсан Материалын Аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудаснаас авах бүрэн боломжтой.

Хууль эрх зүйн мэдээлэл

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон

тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

Construction



Sika Services AG
Tueffenwies 16
CH-8048 Zurich
Switzerland

Phone: +41 44 436 40 40
Telefax: +41 44 436 46 86
www.sika.com